

ҮЙЛЭЭС ҮЙЛ ҮГ БҮТЭЭХ ДАГАВРЫН БАЙРЛАЛЫН ТОГТОЛЦОО

Ж.Ганбаатар

Түлхүүр үг: монгол хэл, үгийн бүтэц, бүтээвэр, хэлний төсөө (analogy), үйл язгуур, дэд бүтээвэр

0. Удиртгал. Монгол хэлний үг бүтээх дагаврыг бүртгэн судалсан ном зохиол, сурах бичгүүдээс үзвэл нэр үг бүтээх дагавраас үйл үг бүтээх дагавар тооны хувьд цөөн байна. Үүнийг судлаачид үйл үг бүтээх дагаврын бүтээлч шинжтэй холбон тайлбарладаг бөгөөд үнэхээр ч нэр үг бүтээх тодорхой дагавруудтай харьцуулахад бүтээлч шинжтэй юм. Үг бүтээх дагаврын давхарлан орох байрыг ажиглахад $S_N \rightarrow S_V \rightarrow S_N$, $S_V \rightarrow S_N \rightarrow S_V$ гэх мэтээр нэр, үйл үг бүтээх дагаврууд салаавчлан орж шинэ үг бүтээх нь $S_N \rightarrow S_N \rightarrow S_N$, $S_V \rightarrow S_V \rightarrow S_V$ гэсэн бүтцээс идэвхтэй хэрэглэгдэж байна. Иймд үйлээс нэр үг бүтээх, нэрээс үйл үг бүтээх дагаврууд нь нэрээс нэр үг бүтээх, үйлээс үйл үг бүтээх дагавраас тоогоороо илүү байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, нэг үгийн аймгийн хүрээнд шинэ үг бүтээхээс хоёр өөр үгийн аймгийн хүрээнд шинэ үг бүтээх нь монгол хэлний хувьд “бүтээлч” шинжтэй болох нь тодорхой харагдаж байна.

Орчин цагийн монгол хэлний хэл зүйн бүтээлүүдийг шүүн үзэхэд үйл үг бүтээхээс нэр үг бүтээх ёс, арга хэрэглүүрийг түлхүү судалсан байна. Бидний тусгайлан авч үзэж буй үйл үг бүтээх тогтолцоог Г.Й.Рамстедт (1912), Г.Д.Санжеев (1963), П.Бямбасан (1977, 1987), Ц.Өнөрбаян (1987, 2000) тэргүүтэй гадаад, дотоодын эрдэмтэн анхаарч судалгааны суурь бүтээлүүдээ нийтлүүлжээ. Эдгээр бүтээлд үйл дагаврыг бүртгэж, дагавар тус бүрийн утга, үүрэг, бүтцийг нь тодорхойлоход голлон анхаарсан байна. Харин бүтээврийн судалгаанд утга, үүрэг, бүтцээс гадна үгийн бүтцэд тохиолдох байрлалыг бас анхаарах хэрэгтэй билээ. Гэвч үйл үг бүтээх дагаврыг тусгайлан судалсан эрдэмтэд байр харьцааг нь төдий л анхааралгүй иржээ. Тиймээс энэхүү өгүүлэлдээ үйлээс үйл үг бүтээх дагаврын байрлалын тогтолцоог орчин цагийн монгол хэлний баримтад тулгуурлан тодруулах зорилго тавьж байна.

1. Үйлээс үйл үг бүтээх дагавар. Үйл үг бүтээх дагаврын судалгаанд дагавар тус бүрийг бүртгэхэд нэлээд анхаарсан боловч судлаачдын санал харилцан адилгүй ажээ. Дагаврын бүртгэл болон үйл үг бүтээх ёсны талаар бичсэн бүтээлүүдээс “үйлээс үйл үг бүтээх дагавар” гэж тодорхойлсон бүтээврүүдийг шүүн нэгтгэхэд 30 орчим дагавар¹ болох авч судалгааны голлох бүтээлүүдэд -л, -р дагаврыг л үйлээс үйл үг бүтээдгийг санал нэгтгэйгээр тэмдэглэжээ. Бусад бүтээврийг нь дагавар мөн, эсэх дээр өнөө хэр судлаачид маргасаар байна.

¹ -л, -р, -га⁴ (-аа⁴), -уул₂ (-лга⁴), -гд (-д, -т), -лд, -лц дагавраас гадна -б (салба), -вч (анивч-), -вчил (баривчил-, яаравчил-), -д, -т, -х (шигд-, бүрх-, улайд-, хавд-), -жс (сунжс-, бүржс-), -жир (сунжир-, тонжир-), -хийл/-лхийл (бодолхийл-, нугалхийл-, үсэрхийл-, шижилхийл-), -мд (найрамд-, тулгамд-, бачимд-), -мс (ухамс/ар/, тоомс/ор/), -на, -ни (тогтно-, хуухина-), -нц (хайнц-, эргэнц-, ээрэнц-), -рх (тунирх-, соёрх-), -ха, -хэ (гунихра-, гальхра-), -чил (ухчил-, гоёчил-, чигчил-), -ш (өгөриш-, баларш-, дарш-), -шир (халир-, үхишр-) болон байдлын бүтээвэр болох -цгаа⁴, -зна⁴, -ч (чих), мөн нийлмэл хэлбэр -аадах⁴ (хэлээдэх, өгөөдөх)-ыг үйлээс үйл үг бүтээх дагаварт багтаажээ. Бас чөлөөт бус язгуураас үйл үг бүтээх дагаврууд (departic verbal suffixes)-ыг зарим судлаач үйлээс үйл үг бүтээх дагаврын ангид оруулан судалсан байдал ажиглагддаг.

Монгол хэлний үгийн бүтэц, үйл үгийн тогтолцоог судлахад хамгийн түрүүнд тулгардаг, судлаачдын санал харилцан зөрүүтэй байгаа зүйл бол үйл үгийн хэв, түүний бүтээврүүдийн тухай асуудал юм. Бид -га⁴ (-аа⁴), -уул² (-лга⁴), -гд (-д, -т), -лд, -лц бүтээврийг үг бүтээх дагаварт тооцон үгийн бүтцэд эзлэх байр харьцааг судалсан (Ганбаатар, 2014, 2015а, 2015b) билээ. Түүнчлэн зарим судлаачийн үйлээс үйл үг бүтээх дагавар гэж үздэг -вч (анивч-), -вчил (баривчил-, яаравчил-), -ж (төлж-, сунж-), -мд (найрамд-, тулгамд-), -мс (тоомс-, ухамс-), -нц (хайнц-, эргэнц-), -ш (өгөрш-, баларш-), -шир (үхшир-, халшир-) зэрэг дагаврын талаар бас урьд нь тусгайлан авч үзсэн² (Ганбаатар, 2011:9-16) болно.

Орчин цагийн монгол хэлэнд нэрээс үйл үг бүтэх загварыг хуулж үйлээс үйл үг бүтээх үзэгдэл хаяа тохиолдоно. Түүнийг өмнөх -вчил, -ж, -ш, -шир дагавар бүхий төсөө (analogy)-өөр үүссэн яаравчил-, үхэж-, дарш-, үхэш-, үхшир- зэрэг үгийн жишээнээс харж болно. Үүнийг Ц.Өнөрбаян "...унжир-, сунжир-, халшир-, үхшир-, баларш-, өгөрш- гэсэн үйл үгсийг бүтээсэн ...-жир, -шир, -ш дагавруудыг ...ангижир-, муужир-, олшир-, удаашир-, зунш-, цэвэрш-, суурьш-, хоногш- зэрэг үгсийг бүтээсэн ...-жир, -шир, -ш дагавраас огт өөр оморфом гэж үзэх ямар ч үндэсгүй (1987:29) гэж үзсэн нь бидний төсөөгөөр үүссэн гэдэг саналтай таарч байна.

Хэвийн дагаврыг эс тооцвол орчин цагийн монгол хэлэнд -л, -р, -ни дагавар үйлээс үйл үг бүтээх бөгөөд -л, -р дагаврын талаар судалгааны бүх бүтээлд үйлээс үйл үг бүтээнэ гэж тэмдэглэжээ. Харин -ни дагаврын талаарх судалгаа бүрэн дүүрэн хийгдээгүй бололтой. Үйлээс үйл үг бүтээх -ни дагавар нь *зовни-, мэнднэ-, тогтно-*³ зэргээр цөөн үгийн бүтцэд тохиолдож байна. Мөн судалгааны санд дусагна-, мартагна-, улигна- зэргээр урагшаа язгууртай харьцахын зэрэгцээ дуурайх язгуураас үйл үг бүтээх -л, -ш дагавар (уйлагна-, гиншигнэ-)-тай харьцдаг -гна⁴ дагавар бүхий цөөн үг бүртгэгдсэн⁴ байна. Тухайн дагавар бүхий зарим үгс нутгийн аялгуунд -на (мартагна- ~ мартна- /буриад/) дагавартай тохиолдож байна. Энэхүү дагаврын байр харьцаа, утга үүргийг ажиглахад -ни дагаврын хувилбар гэж үзэж болохоор аж. Ингэж үзвэл орчин цагийн монгол хэлэнд хэвийн дагавруудаас гадна үйлээс үйл үг бүтээдэг -р, -л, -ни (-гна) дагавар байна.

2. Үйлээс үйл үг бүтээх дагаврын байрлал. Үйл үг бүтээх дагаврууд үгийн бүтцэд урагшаа үйл язгуур, үйл үг бүтээх зарим дагавартай, хойшоо нэр үг бүтээх, тэмдэг нэр бүтээх дагавруудтай харьцах байрлалд тохиолдоно. Тэдгээрийг дагавар тус бүрээр нь авч үзье.

2.1. Урагшаа үйл үг бүтээх дагавартай харьцах нь. Үйлээс үйл үг бүтээх дагавар урагшаа нэрээс үйл, үйлээс үйл, чөлөөт бус язгуураас үйл үг бүтээх дагавартай тус тус харьцана.

Нэрээс үйл үг бүтээх дагавартай харьцах нь: Нэрээс үйл үг бүтээх дагаврын ард үйлээс үйл үг бүтээх дагавар байрлаж, үүсгэгч үндсийн утгаар илэрч байгаа үйлийг давтан үйлдэх, мөн ямар нэг хүчний нөлөөгөөр алгуур болох утга тус тус заадаг байна. Үгийн бүтцэд -р дагавар урагшаа -л, -с (төвлөр-, саймсар-)-тай харьцдаг бол, -л дагавар урагшаа -д/-с, -ш (эвдэл-, идээшил-)-тай, -р дагавар урагшаа -шаа (зөвшөөр-?) дагавартай харьцаж бүтсэн нэгжээд жишээ бүртгэгджээ. Үүнээс хамгийн бүтээлч загвар нь “-л+-р” (6 үг), “-с+-р” (3 үг) дараалал болно.

² Монгол хэлэнд хувиргалаар бүтсэн *балар-* (ул мөр, тэмдэг арилах), *өгөр-* (эд юмсын өнгө гутааж хүүришин хэврэгших) хэмээх үйл үндэс байх боловч *баларш-, өгөрш-* нь судлаачдын тэмдэглэсэн шиг үйл үндсээс үүсээгүй болно. Миний бие ч “Монгол хэлний үйлээс үйл үг бүтээх хэдэн дагаврын тухайд” (2011) өгүүлэлдээ үйлээс үйл үг бүтээх *-ш, -ж* дагавар байна гэж үзэж байсан билээ. Гэвч энэ нь эндүүрэл байсныг батлах хэлний баримт хангалттай бий.

³ Түүхэн үүднээс *эмгэнэ-* (*emgeni-*), *эснэ-* (*eseni-*), *өрнө-* (*örni-*) зэрэг үгийн бүтэц дэх *-ни* дагавар ч гарлын хувьд холбогдох биз.

⁴ Үгийн бүтцэд *-гна*₄ дагаврын ард үйлээс тэмдэг нэр бүтээх *-уур*₂ (*гонигонуур, уйлагнуур, чичгэнүүр*) дагавар тохиолдож байна.

Хүснэгт 1: $S_{V.V}$ урагшаа $S_{N.V}$ -тай харьцаж бүтсэн үгийн тоо

дагавар	-л	-р
-д (-с)	+ (1)	-
-л	-	+ (6)
-с	-	+ (3)
-ш	+ (1)	-
-шаа	-	+ (1)*

-шаа⁴ дагаврын ард үйлээс үйл үг бүтээх -р дагавар орж бүтсэн зөвшөөр- хэмээх үг дундад үеийн монгол хэлний дурсгалд зөвшөө- гэсэн хэлбэрээр тохиолддог. Гэтэл бэрхшээ-, сайшаа-, муушаа-, адилшаа-, зүрхшээ-, тээршээ-, өршөө-, эрхшээ- зэрэг -шаа⁴ дагавар бүхий бусад үгийн бүтцэд -р дагавар тохиолдохгүй байна.

Үйлээс үйл үг бүтээх дагавартай харьцах нь: Нэг үгийн аймгийн дагаврууд дараалан орж үг бүтэх нь монгол хэлний хувьд бүтээлч бус загвар. Ялангуяа үйлээс үйл үг бүтээх дагавар үгийн бүтцэд дараалан орох тохиолдол тун цөөн аж. Хэлний баримтыг шүүн нягтлахад -л, -ни, -р дагавар нэг үгийн бүтцэд угсран орсон тохиолдол таарсангүй. Судалгааны санд, -л, -р дагавар урагшаа -га⁴ дагавартай харьцаж бүтсэн амьсгал-, дэлгэр-, зөөтгөр-, нийтгэр-, тулгар- зэрэг цөөн үг бүртгэгдсэн байна. Эдгээрийг зарим судлаач дагаврын байрлалыг зөрчих тохиолдол гэж үзэх хандлага ажиглагддаг боловч “-га + -р” дарааллыг үйлдэх утгын бүрэлдэхүүнтэй дагаврын ард үйлийн болц байдлын утга илтгэх бүтээвэр ордог зүй тогтолтой адилтган үзэж болно.

Хүснэгт 2: $S_{V.V}$ урагшаа $S_{V.V}$ -тай харьцаж бүтсэн үгийн тоо

дагавар	-л	-р
-га	+ (1)	+ (4)

Үгсийн бүрэлдэхүүнд -л дагавар урагшаа -га⁴ дагавартай харьцаж бүтсэн амьсгал- хэмээх өвөрмөц бүтэцтэй үг буй. Тухайн үг дундад үеийн монгол хэлний дурсгалуудад амьсга- гэсэн хэлбэрээр тэмдэглэгдэн үлдсэн байх бөгөөд Б.Ринчен ч өөрийн судалгааны бүтээлдээ “амьсгалах” бус “амьсгах” хэлбэрээр хэрэглэжээ. Тухайлбал: “амисгах гэдгийн утга ч а-ми-с-га-х гэдгийн салдаг байдлыг амисахад хүрүүлэх гэсэн утгаас мэдэгдэх буюу” (1966:19) гэж бүтэц, утгыг тайлбарласан байна.

Саяхныг хүртэл амьсга- хэлбэрийг хэрэглэж байгаад түүний ард -л дагавар залгажээ. Энэ үг амьсгал хэмээх нэр үгээс “хувиргал” (conversion)-аар үүссэн үү, эсвэл үйл үндэс (амьсга-)-д давтан үйлдэх утгатай -л дагавар залгасан уу? гэдэг нь сонирхолтой байна. Хоёр дахь тохиолдол нь гэвэл -л дагавар үйлээс үйл үг бүтээх дагаврын ард, мөн хэвийн дагаврын ард орсон өөр жишээ олдсонгүй. Ямартай ч тун саяхан үүссэн үг гэдэг нь маргаангүй.

Чөлөөт бус язгуураас үйл үг бүтээх дагавартай харьцах нь: Үйлээс үйл үг бүтээх -л, -р дагаврын урагшаа чөлөөт бус язгууртай харьцах байр дараах байдалтай байна. -л дагавар урагшаа үйл байдлыг дүрслэх язгуураас үйл үг бүтээх -ч (сийчил-)-тай, -р дагавар урагшаа үйл байдлыг дүрслэх язгуураас үйл үг бүтээх -л (нугалар-)-тэй, мөн дүр байдлыг дүрслэх язгуураас үйл үг бүтээх -ай³ (ээтийр-)- дагавартай харьцаж бүтсэн нэжгээд үг илэрлээ.

-л дагавар урагшаа дуу авиа дуурайх язгуураас үйл үг бүтээх -ш (шившил-)-тай, -р дагавар урагшаа дуу авиа дуурайх язгуураас үйл үг бүтээх -ги, -ш (нүргэр-, шагшир-) дагавартай харьцаж бүтсэн үгс буй.

Хүснэгт 3: S_{V-V} урагшаа S_{P-V} -тай харьцаж бүтсэн үгийн тоо

дагавар	-л	-р
-л	-	+ (1)
-ч	+ (1)	-
-ай	-	+ (1)
-ги	+ (13)	+ (2)
-ш	+ (4)	+ (4)

2.2. Хойшоо бусад үгийн аймгийн дагавартай харьцах нь. Үйл үг бүтээх дагавар хойшоо үйлээс нэр, үйлээс тэмдэг нэр бүтээх дагавартай харьцана.

Үйлээс нэр үг бүтээх дагавартай харьцах нь: -л дагавар хойшоо нэр үг бүтээх -аа⁴, -вар⁴, -га⁴, -л, -лт, -уур² (татлаа, таталбар, арчилгаа, дарлал, базлалт, чичлүүр) дагавартай харьцаж тус бүр 2-4 хүртэлх үг бүтээжээ.

-ни дагавар хойшоо нэр үг бүтээх -л дагавартай харьцаж бүтсэн зовнил, тогтнол зэрэг 3 үг бүртгэгдсэн байна.

-р дагавар хойшоо нэр үг бүтээх -аа⁴, -г, -га⁴, -гч, -дас⁴, -л, -лга⁴, -лт, -мж, -хуй² (ээдрээ, цацраг, захиргаа, буурагч, шүүрдэс, гутрал, захирлага, төвлөрөлт, мэдрэмж, мэдрэхүй) дагавартай харьцана. Хойшоо нэр үг бүтээх дагавартай харьцах байдлыг ажиглахад “-р+-дас” (шүүрдэс), “-р+-хуй” (мэдрэхүй) дарааллаар бүтсэн тус бүр нэг үг, бусад тохиолдолд 2-26 хүртэлх жишээ бүртгэгджээ.

Хүснэгт 4: S_{V-V} хойшоо S_{V-N} -тай харьцаж бүтсэн үгийн тоо

дагавар	-аа	-вар	-г	-га	-гч	-дас	-л	-лга	-лт	-мж	-уур	-хуй
-л	+ (4)	+ (2)	-	+ (5)	-	-	+ (2)	-	+ (1)	-	+ (7)	-
-ни	-	-	-	-	-	-	+ (3)	-	-	-	-	-
-р	+ (11)	-	+ (1)	+ (4)	+ (6)	+ (1)	+ (26)	+ (4)	+ (23)	+ (4)	-	+ (1)

Үйлээс тэмдэг нэр бүтээх дагавартай харьцах нь: -р дагавар хойшоо -аа⁴, -маг⁴, -мал⁴, -мхай⁴, -нги³, -нгуй², -уу², -хай³, -шгүй (цавчраа, шүүрмэг, хавсармал, мэдрэмхий, гутранги, буурангуй, цайруу, эвдэрхий, эдгэршгүй) дагавартай харьцаж үг бүтээнэ. Үүнээс бүтээлч бус дараалал нь “-р+-аа” (цавчраа), “-р+-маг” (саармаг, шүүрмэг), “-р+-нги” (гутранги) бөгөөд бусад тохиолдолд долоо болон түүнээс дээш үг бүтжээ.

-л дагавар хойшоо -мхай³, -нгуй² (дарламхай, оргилонгуй)-тай, -ни дагавар -нгуй², -уун² (зовнингуй, тогтнуун)-тай харьцаж бүтсэн тус бүр 1-3 хүртэлх үг бүртгэгджээ.

Хүснэгт 5: S_{V-V} хойшоо S_{V-Adj} -тай харьцаж бүтсэн үгийн тоо

дагавар	-аа	-маг	-мал	-мхай	-нга	-нгуй	-уу	-хай	-шгүй
-л	-	-	-	+ (1)	-	+ (3)	-	-	-
-ни	-	-	-	-	-	+ (1)	-	-	-
-р	+ (1)	+ (2)	+ (10)	+ (7)	+ (1)	+ (12)	+ (8)	+ (14)	+ (7)

3. Үйл үг бүтээх дагаврын утгын харьцаа. Хэлний бүтээвэр бүр утгатай, бүтээврүүдийн хоорондох харьцаа ямагт утгат харьцаа байна. Монгол хэлний нэг үгэнд үйлдвэрлэл, хөдөлмөрчин, хамтралжуулалт гэх мэтээр “2 - 6 дагавар давхарлан орж түүнээс дээш давхарлан орох боломжийг хязгаарладаг байна” (Өнөрбаян, 2004:32). Үгийн бүтцэд дагаврууд давхарлан орохдоо өөрчилж үл болох хатуу дэс дарааллаар байрладаг. Мөн үг бүтээх дагавруудыг санасан

бүх боломжоор залгаж шинэ үг бүтээж болдоггүй нь хэлний дотоод зүй тогтол буюу дагавар дагавартайгаа харьцах утгын холбоотой шууд хамааралтай аж.

“Нэг” үгийн аймгийн дагаврууд дараалан орж үг бүтээх нь “өөр” үгийн аймгийн дагаврууд салаавчлан орж үг бүтээхээс бүтээлч бус болох тухай өмнө дурдсан билээ. Үгийн бүтцэд үйл үг бүтээх дагаврууд шууд дараалан орох нь нэр үг бүтээх дагаврууд давхарлан орохоос цөөн тохиолдох боловч доорх хэдэн хэв маяг буй.

Нэг. Дуу авиа дуурайх язгуураас үйл үг бүтээх дан (CV) бүтэцтэй дагаврын араас давтан үйлдэх утгатай -л дагавар орж тухайн дуу чимээ олонтоо дуугарах, үргэлжлэн сонсогдох утга илтгэнэ.

Хүснэгт 6: $S_{(P-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-ги	дуу авиа, анир	-л	давтан үйлдэх	нүргэл-	13
-ш	чимээ заах			шившил-	4

Дуу авиа дуурайх язгуураас үйл үг бүтээх нийлмэл бүтэцтэй дагавруудын ард -л ордоггүй. Учир нь, -гина³, -жигна³, -тна⁴ дагаврын бүтэц дэх -на⁴ бол -л дагаврын хувилбар шинжтэй байсан бөгөөд түүхэн хувьслын үр дүнд нэгдэж, нийлмэл нэг дагавар болон хөгжжээ. -хир (-kira, -kire) дагаврын бүтэц дэх -р ч мөн адил гарлын үүднээсээ тус дагавартай холбогдоно.

Хоёр. Үйлдэх утгын бүрэлдэхүүнтэй дагаврын араас “тухайн үйлийн нөлөөгөөр бий болох утга” бүхий -р дагавар орно.

Хүснэгт 7: $S_{(N-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-л	үйлдэх	-р	үйлийн нөлөөгөөр бий болох утга	таглар-	6

Хүснэгт 8: $S_{(V-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-га	үйлдэх	-р	үйлийн нөлөөгөөр бий болох утга	тулгар-	4

Хүснэгт 9: $S_{(P-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-л	үйлдэх	-р	үйлийн нөлөөгөөр бий болох утга	нугалар-	1

Гурав. Цөөн тохиолдолд давхарлан орж буй дагавруудын сүүлийнх нь дэд бүтээврийн шинжтэй хэрэглэгдэх тохиолдол ажиглагдаж байна.

Хүснэгт 10: $S_{(N-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-д (-с)	зохисгүйдэх	-л	дэд бүтээврийн шинжтэй	эвдэл-	1
-с	хүсэх тэмүүлэх			хамсар-	3
-ш	хэвшин тогтох			идээшил-	1

Хүснэгт 11: $S_{(V-V)} + S_{(V-V)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-га	үйлдэх	-л	дэд бүтээврийн шинжтэй	амьсгал-	1
-шөө/-аа	үйлдэх	-р		зөвшөөр-	1

Хүснэгт 12: $S_{(p-v)} + S_{(v-v)}$ дагаврын утгын харьцаа

дагавар	утга	дагавар	утга	жишээ	тоо
-ч	давтан үйлдэх	-л	дэд бүтээврийн	сийчил-	1
-ш	давтан үйлдэх		шинжтэй	шагшир-	4

Тухайлбал, чөлөөт бус язгуураас үйл үг бүтээх -ч, -ш дагаврын ард -л дагавар орсон байрыг ажиглахад, давтан үйлдэх утгатай -ч (сийч-: хутга мэсээр олонтоо сийлэх) дагаврын ард мөн давтан үйлдэх утгатай -л дагаврыг үүрэггүй хэрэглэжээ. “Шаазгай шагших”, “шаазгай шагшрах” хоёрт ижилхэн шаазгай шувууны “шаг шаг дуугарах” авиаг тэмдэглэсэн нь -р дагаврыг үүрэггүй хэрэглэсэн болохыг илтгэх аж.

Үйл язгуур, үндсээс үйл үг бүтээх дагаврын нэг үгийн бүтцэд угсран орох дарааллыг утгын бүрэлдэхүүнээр нь дээрх гурван хэв шинжид хувааж болохоор байна.

4. Дүгнэлт. Үйлээс үйл үг бүтээх дагавар тус бүрийн үгийн бүтцэд урагшаа, хойшоо нэрээс үйл үг бүтээх, үйлээс үйл үг бүтээх, үйлээс нэр үг бүтээх, үйлээс тэмдэг нэр бүтээх дагавартай харьцах байрлалыг цахим сан болон үг задлуурын программ ашиглаж тогтоолоо. Энд анхаарал татаж буй нь, нэрээс үйл үг бүтээх зарим дагавар, тухайлбал, -ш (хэвш-), -шир (удаашир-) дагаврын төсөө (analogy)-өөр үйл язгуураас үйл үг (дарш-, үхэш-, үхшир-) бүтээх цөөн тохиолдол байна.

Монгол хэлний хувьд өөр өөр үгийн аймгийн дагаврууд салаавчлан орж үг бүтээх нийтлэг хэв шинжтэй ч нэг үгийн аймгийн дагаврууд хоёр ба түүнээс дээш тоогоор давхарлан орох явдал бий. Ингэхдээ “үйлдэх” утгын бүрэлдэхүүнтэй дагаврын араас “үйлийн нөлөөгөөр бий болох утга” бүхий дагавар орох ерөнхий зүй тогтолтой ажээ. Мөн “үйлдэх” утгын бүрэлдэхүүнтэй дагаврын ард давтан үйлдэх утга бүхий дагавар орохдоо дэд бүтээврийн шинжтэй болдог үзэгдэл ажиглагдаж байна.

Abstract

The paper deals with the distribution of verb formation suffixes from verb and analyzes them in terms of their forward and backward relation to other suffixes in word structure based on some examples. In Mongolian, the occurrence in which suffixes of the same parts of speech exist in a sequence of a word structure is uncommon than the occurrence in which suffixes of different parts of speech are in the sequence of the word structure.

Номзүй

- Ramstedt G. J.** 1912. *Zur Verbstammbildungslehre mongolisch - türkischen Sprachen*. JSFOu, Baud 28 (3). SS. 1-84.
- Бямбасан П.** 1970. *Үйл үгийн зарим язгуур*. *Studia Mongolica*. Т-VII. Уб., х. 271-278.
- Бямбасан П.** 1977. *Үйл үг бүтээх дагаврууд*. УБДС-ийн Эрдэм шинжилгээ, заах аргын бичиг, 1(12): 3-10.
- Бямбасан П.** 1987. *Үйл үгийн хэв. Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт*. Уб., 193х.
- Ганбаатар Ж.** 2011. *Монгол хэлний үйлээс үйл үг бүтээх хэдэн дагаврын тухайд*. Хэл зохиол судлал. 4 (36): 9-16.
- Ганбаатар Ж.** 2014. *Үг бүтээх дагаврын нэмэлт байр*. Хэл зохиол судлал. 7 (39): 28-37.
- Ганбаатар Ж.** 2015. *Именное словообразование от глаголов с залоговыми аффиксами*. Вестник БНЦ СО РАН. Вып. 2. Улан-Удэ, стр. 167-174.